



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2020 оны 03 сарын 31 өдөр

Дугаар 109

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас
хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.4.4, 6.6 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны “Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 268 дугаар тогтоолын 4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Сэлэнгэ аймгийн Шаамар суман дахь Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, сэргээн засварлах боломжгүй болсон, хоёр удаагийн нээлттэй дуудлагын худалдаагаар оролцогч ирээгүй нийт 13,860,000.00 /арван гурван сая найман зуун жаран мянган/ төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан автомашин, тракторыг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Өнөрбаяр, Сэлэнгэ аймгийн Шаамар суман дахь Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн захирал Б.Хишигжаргал нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, сэлбэгээр ашиглах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу Байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Акталж, данснаас хасаж сэлбэгээр худалдсан автомашин, тракторын улсын дугаарыг улсын бүртгэлээс хасуулсан тодорхойлолт, дээрх арга хэмжээний биелэлтийн хамт 2020 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА


З.МЭНДСАЙХАН

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Д.НАРАНГЭРЭЛ

0000021

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны 03 дүгээр сарын 3-ны өдрийн
109 дугаар тогтоолын хавсралт



Сэлэнгэ аймгийн Шаамар суман дахь Мэргэжил сургалт
үйлдвэрлэлийн төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй
акталж, данснаас хасах автомашин

Д/д	Автомашины марк, улсын дугаар, арал	Үйлдвэрлэсэн , ашиглалтад орсон он	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)
1	Бонго киа, 74-87 УБЦ, арал № 1100019930	1998/ 2001	9,800,000.00	9,800,000.00
2	Жижиг оврын трактор	1996/ 2001	4,060,000.00	4,060,000.00
	Нийт дүн		13,860,000.00 /арван гурван сая найман зуун жаран мянган/	13,860,000.00 /арван гурван сая найман зуун жаран мянган/